

ОЮУТНЫ МЭДЛЭГ, ЧАДВАРЫГ ТЕСТИЙН АРГААР ҮНЭЛСЭН ҮНЭЛГЭЭНД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН НЬ

(МОНГОЛ ХЭЛ БИЧИГ НАЙРУУЛГА ЗҮЙН ХИЧЭЭЛИЙН ЖИШЭЭН ДЭЭР)

Ч.Бямбацэцэг, магистр, МУБИС

Abstract: The importance of the research is focused on Action Research and Qualitative research with advantages of teacher's reflection and making assessment on own work, applying new teaching methodologies for supporting students' learning process, evaluating students new knowledge with support of objectives of teaching, renewing the assessing methods to increase efficiency of learning and teaching.

According to the learners' demands and interests we have to increase the quality of educational service and develop every child in today's society, it is so important supporting their talents and interests we need to organize learning activities.

With this demand, I started the paper concerning the teachers should study or conduct the research on the learner and do the action research, organize study-centered learning activities to develop every child.

Therefore through this paper, we have used the action research on Mongolian language and stylistics taking some enquiries and tests and have done some qualitative assessment. Giving qualitative assessment, we have tried observing in what ways we can plan and implement the progress in students' further learning activities, using various forms of tests we have analyzed what kind of opportunities to evaluate students have.

Түлхүүр үг: Үйлийн судалгаа, стандарт ба стандарт бус үнэлгээ, зөв бичих дүрэм, сонгох тест, мэдлэг

Удиртгал

Өнөөгийн нийгэмд боловсролын үйлчилгээний чанарыг үр ашигтай, хүртээмжтэй нэмэгдүүлэх, суралцагчдын эрэлт хэрэгцээ, хүсэл сонирхолд нийцүүлж, хүүхэд нэг бүрийг хөгжүүлж, тэдний авьяас сонирхлыг нь дэмжин сургалтын үйл ажиллагааг зохион байгуулах шаардлага нэн чухлаар тавигдаж байна.

Энэхүү шаардлагын дагуу багш нар хүүхэд нэг бүрийг хөгжүүлэхийн тулд сурагчаа судлах, үйлийн судалгаа хийх, судалгаат хичээлийг зохион байгуулах хэрэгцээ шаардлага тулгарч байна.

Монгол хэл бичиг найруулгазүйн хичээлээр оюутнаас авсан сорил тестийн хүрээнд үйлийн судалгаа, чанарын үнэлгээ хийснээр оюутны цаашдын суралцах үйл ажиллагаанд ахиц өөрчлөлтийг ямар замаар төлөвлөн хэрэгжүүлэх боломж бий эсэхийг тандан тестийн олон хэлбэрээр оюутныг үнэлэх ямар боломж байгаад дүн шинжилгээ хийхийг зорьсон болно.

Судалгааны ажлын хүрээнд

Багш суралцагчийг үнэлэх явцдаа тестийн ямар даалгаврыг түлхүү хэрэглэж буй эсэх, тухайн суралцагчийн түвшинг ялган тогтоохоос гадна юун дээр алдаж буйг илрүүлж, ололт, дутагдалтай тал дээрээ дүн шинжилгээ хийж, хэрхэн үйл ажиллагаагаа сайжруулж болох арга замыг

тодорхойлох зорилт дэвшүүлээ.

Монгол хэлний зөв бичих дүрмийн чадварыг шалгахдаа стандарт бус сорилын аргыг хэрэглэж, оюутны мэдлэг чадварыг үнэлэхдээ зөв бичих дүрмийн мэдлэг, найруулгын шаардлага хэм хэмжээг хэрхэн эзэмшсэн байдлыг тогтоосон үнэлгээний талаар авч үзнэ. Зөв бичих дүрмийн мэдлэг, чадвар үнэлэх судалгаанд БОСС, БС-ийн СӨБС-ийн 120 оюутан хамрагдсан бөгөөд үнэлгээг математик- статистикийн аргаар боловсрууллаа.

Үндсэн хэсэг

Үйлийн судалгааны үзэл санаа анх 1940-өөд оны тэртээгээс үүсэлтэй бөгөөд АНУ-ын эрдэмтэн К.Левин “аливаа өөрчлөлтийг судалгаанд үндэслэн хийх, асуудлыг шийдэхийн тулд судалгааг үйлээс нь салгаж болохгүй” (Пүрэвдорж, 2009) гэсэн санааг гаргасан бол Боловсролын салбар дахь үйлийн судалгааг анх Колумбын их сургуулийн профессор Стефан Корей эхлүүлсэн бөгөөд тэрээр “Үйлийн судалгаа нь өдөр тутмын практик үйл ажиллагааг өөрчлөхөд илүү үнэ цэнэтэй” хэмээн үзсэн байдаг. Үйлийн судалгааг 1950-иад оны үед шинжлэх ухаанч биш хэмээн шүүмжлэх болжээ. 1970-аад оноос дахин энэхүү асуудал яригдсан бөгөөд Нопке Стивинсон “Багшийн мэргэжлийн хөгжлийн арга хэрэгсэл”, (Пагмасүрэн, 2015) Б.Жадамбаа “Үйлийн судалгааны мөн чанар нь математикийн дараалан дөхөх арга юм”

(Жадамбаа, Чимэдлхам, 2011) Авсралийн судлаач Кеммис болон Таггарт нар “Үйлийн судалгаа нь тодорхой шийдэл олоход чиглэсэн баг хамт олон болон хувь хүний зүгээс хийж буй судалгаа” (Жадамбаа, Чимэдлхам, 2011), Ж.Дьюгийн ажил амьдралынхаа явцаас сурах, “туршлагаасаа сурах” (Пүрэвдорж, 2009, х.371-427) гэсэн баримтлалд тус тус үндэслэдэг байна.

Эндээс авч үзвэл үйлийн судалгаа гэдэг нь тодорхой нэг ажлыг сайжруулах зорилгоор тухайн чиглэлээр ажиллаж байгаа хүмүүсийн өдөр тутмын практик үйлд үндэслэгддэг ажээ.

Энэхүү санаанаас үүдээд монгол хэл бичиг, найруулгазүйн хичээлийн эхний модуль сэдвийн хүрээнд хэрэглэсэн тестийн агуулгад үйлийн судалгаа хийж, тестийн олон хэлбэрээр оюутныг үнэлэх явцад чанарыг нэмэгдүүлэх ямар боломж байгаа эсэхийг илрүүлэхийг зорилоо.

Монгол хэлний найруулгазүйн хичээл нь шинэчилсэн сургалтын төлөвлөгөөгөөр 3 кредитийн хичээл бөгөөд үүнээс хэлзүй зөв бичих дүрмийн хэсэг хөтөлбөрийн нийт цагийн 25%-ийг эзэлж байна.

Багшаас оюутныг үнэлэхдээ хэрэглэдэг түгээмэл аргын нэг бол тестийн арга юм. Тестийн аргын давуу болон сул талаар мэргэжлийн ном зохиолд олонтоо дурдсан байдаг. “Тест нь дотроо стандарт ба стандарт бус гэсэн 2 хэлбэртэй байх

ажээ. Нэгдсэн стандартын дагуу үнэлэгддэг асуулгаас бүрдсэн тестийг стандарт тест гэнэ. Ийм тестийг мэргэжлийн хүмүүс, мэргэшсэн байгууллага зохиож өргөн хэрэглээнд гаргадаг бөгөөд их сайн туршигдаж, олон удаа шалгагдсан учраас баталгаа муутай асуултууд нь хасагдсаар ихээхэн үнэмшил сайтай болсон байдаг. Багш бид өөрсдөө зохиож багшлах үйл ажиллагаандаа ашигладаг тест нь стандарт бус бөгөөд үнэлгээ хийхэд зориулагдсан даалгавруудын эмхэтгэл, хэмжүүр юм...” (Пүрэвдорж.Ч, 2009)

Суралцагчдаас авсан тестийн асуултын хэлбэрийг авч үзвэл:

Зөв, буруу хариулт сонгох тест

Зөв бичих дүрмийг тайлбарлан бичих

Зөв бичих дүрэмд тохирох жишээ зохион бичиж, утга тайлбарлах

Эхийг гүйцээн бичих гэсэн хэлбэрүүдийг тус тус хэрэглэсэн болно.

Тестийн эхний хэсэг болох 17 даалгавраас 9 нь буюу 53% зөв, буруу хариулт сонгох тест, өгөгдсөн дүрэмд тохирох жишээ зохион бичиж, утга тайлбарлах тест 24%, зөв бичих дүрэм тайлбарлах, өгөгдсөн тохиолдлыг гүйцээн бичих гэсэн хэлбэр бүхий даалгавар нийт асуултын 12% -ийг эзэлж буйгаас харахад тестийн ихэнх нь сонгох тестийн хэлбэр эзэлж байна.

Хүснэгт 1

Зөв, буруу хариулт сонгох тест

Тестийн асуулт	Зөв		Буруу	
	Нийт	Хувь	Нийт	Хувь
Аль үг бусдаасаа онцлогтой вэ?	75	62%	45	38%
Алдаатай үг бүхий хэсэг олох	92	77%	28	23%
Залгавар залгахад аль үг нь бусдаасаа ялгаатай вэ?	149	62%	91	38%
Алдаатай бичсэн үгийг олох	136	56%	104	43%
Зөв бичсэн үг олох	81	68%	39	32%

I Зөв буруу хариулт сонгох тестэд эр, эм эгшгийн дүрэм, гээгдэх, гээгдэхгүй эгшгийн дүрэм, дараалсан хоёр, гурван гийгүүлэгчийн дүрэм, үйл үг бүтээх-Л дагаврын дүрэм, хатуу, зөөлний тэмдгийн дүрэм тус тус оржээ. Энэхүү сорилын асуултад хариулсан байдлыг авч үзвэл:

Судалгаанд хамрагдсан нийт 120 оюутны 68-77% нь үгийн зөв, буруу бичсэнийг олох чадвартай нь тогтоогдлоо. Үүнд, суралцагч судалсан материалыг сэргээн санах үйл явцыг илэрхийлэхдээ хэвшиж заншсан зүйл, загвар, тогтсон чиглэл, дараалалд хариулж буй нь Блүмийн

таксономийн танин мэдэхүйн “мэдлэгийг сэргээн санах” түвшний мэдлэгийг эзэмшсэн болохыг харуулж байна. /Хүснэгт.1/

II. Зөв бичих дүрмийг тайлбарлан бичих сорилд дүрэм тайлбарлах, тухайн дүрэмд тохирсон жишээ зохион бичих даалгаварт эр, эм эгшгийг зөв бичих, гээгдэх эгшгийн тохиолдол, хатуу зөөлний тэмдэг, зарим бүтээврийг зөв бичих, дараалсан 3 гийгүүлэгчийн дүрэм тус тус багтсан болно. Эдгээр даалгаврыг гүйцэтгэсэн байдлыг авч үзэхэд тухайн үгийн зөв бичих дүрмийг зөв

тайлбарлан бичих чадвар 32%, дутуу буюу буруу хариулсан тохиолдол 68%, дүрэмд тохирсон жишээ зохион зөв бичих чадвар 43%, дутуу буюу буруу хариулсан 57%-тай байгаа нь танин

мэдэхүйн эхний 2 шат болох мэдлэг, ойлголтын түвшний чадвартай болохыг харуулахын дээр суралцагч олсон мэдлэгээ хэрэглэх чадвар дутмаг болохыг харуулж байна.

Хүснэгт 2

Зөв бичих дүрмийг тайлбарлан бичих тест

Тестийн асуулт	Зөв		Дутуу		Буруу	
	Нийт	Хувь	Нийт	Хувь	Нийт	Хувь
Тухайн үгийн зөв бичих дүрэм тайлбарлан бичих	39	32%	33	28%	48	40%
Дүрэмд тохирох жишээ бичих	51	43%	40	33%	29	24%

III. Үгийн утга тайлбарлах, жишээ зохион бичих даалгаварт журамлагдсан үгсээс хувилбартай бичих үгс тайлбарлах, ойролцоо утгатай үгийн эгнээ үүсгэх, үгийн олон утгын тайлбарыг зөв үгтэй холбох бүхий асуултад хариулсан байдлыг авч үзвэл,

Хүснэгт 3

Зөв бичих дүрэмд тохирох жишээ зохион бичиж, утга тайлбарлах тест

Асуулт	зөв		дутуу		буруу	
	нийт	хувь	нийт	хувь	нийт	хувь
Дүрэмд тохирсон жишээ бичих	32	26%	36	30%	52	43%
Журамласан үг тайлбарлах	10	8%	69	58%	41	34%
Үгийн олон утга тохируулах	63	53%	46	38%	11	9%
Ойролцоо үгийн эгнээ үүсгэх	7	6%	91	75%	22	18%

Журамласан үгийн утга тайлбарлан бичих даалгаварт 92% нь хангалтгүй, үгийн олон утгыг тохирох үгтэй холбох асуултад 53% нь зөв хариулж, ойролцоо үгийн эгнээ үүсгэж, утга ялгарах өгүүлбэр зохион бичих чадварыг шалгах даалгаварт 93% нь хангалтгүй хариулснаас үзэхэд оюутан тухайн нөхцөлд тохирсон жишээ, тайлбар бичих, үгийн утга тайлбарлан бичих чадвар сул байгааг харуулж байна. Энэ нь суралцагчид

бүтээлч эрэл хайгуул хийх, шинжлэн тогтоох, мэдлэгээ хэрэглэх чадвар дутмаг болохыг харуулж байна.

IV. Өгөгдсөн тохиолдлыг гүйцээн бичих даалгаварт цэг тэмдгийн дүрэм, найруулгын ба найруулгын бус алдааг тоочих, найруулгагүйн шаардлага, ном унших арга зэргийг багтаасан асуултууд байлаа.

Хүснэгт 4

Эхийг гүйцээн бичих тест

Тестийн асуулт	Зөв		Дутуу		Буруу	
	Нийт	Хувь	Нийт	Хувь	Нийт	Хувь
Цэг тэмдгийн дүрэм	65	54%	12	10%	43	36?3640%
Ном унших арга, найр. Шаардлага	17	14%	62	52%	29	34%

Энэхүү даалгаварт хариулсан байдлаас харахад танин мэдсэн зүйлээ хэрэглээ болгох, дүгнэж бичих чадвар сул болох нь ном унших арга барил, найруулгын алдааны төрлүүд, найруулан бичих шаардлага гэсэн асуултад хангалтгүй дутуу буюу буруу хариулсан байдлаас харж болох юм. /Хүснэгт. 4/

Тестийн хоёрдахь хэсэг болох зөв бичих дүрэм шалгах бүхий түүвэр өгүүлбэр бичсэн байдлаас харахад

Хүснэгт 5

Түүвэр өгүүлбэр дэх алдааны тоо

Алдсан үгийн тоо	Оюутны тоо
Алдаагүй бичсэн	10
1-5	25
6-10	45
11-15	33
16-20	4
21-25	3

Зөв бичих чадварыг шалгах зорилгоор түүвэр өгүүлбэр бичүүлж авахад алдаагүй бичсэн оюутнууд нийт оюутны 10%, 1-5 үг алдсан оюутан нийт оюутны 20%, 6-10 үг алдсан 37%, 11-15 үг алдсан 27%, 16-20 үг алдсан 3%, 25-с дээш үг буруу бичсэн 2% байгаа нь оюутнууд алдаагүй зөв бичих чадвар сайн хэвшээгүйг харуулж байна.

Алдаж буй үгийг зөв бичих дүрмээр бүлэглэн авч үзвэл үйл үг бүтээх-Л дагавар, хатуу зөөлний тэмдгийг зөв бичих, гээгдэх ба гээгдэхгүй эгшгийн дүрэм, нэр ба үйл үг ялгах хамаатуулах-Х, асуух, батлах баймж, “вэ (бэ) л, ч, даа⁴ зэргийг буруу бичих тохиолдол гарч байна.

ДҮГНЭЛТ

Дээрх судалгааны дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

1. Суралцагчаас шууд хариулт шаардсан даалгавар бус, бодож эргэцүүлж тунгаан бодуулсан, эрэл хайгуул хийхүйц бүтээлч байдлаар оюутныг үнэлэх даалгавар боловсруулахад анхаарч, нэг хэлбэрийн тестийн хэлбэрээс зайлсхийх шаардлагатай болохыг харуулж байна.
2. Оюутнууд дүрэм тайлбарлан бичих, жишээ зохион бичих, үгийн олон утга тайлбарлах, ойролцоо үг зохиох, ойролцоо үгийн үүр

үүсгэх зэрэг асуултад хангалтгүй хариулж буй нь суралцагчдын бүтээлч сэтгэхүй дутмаг болохыг харуулж байна.

3. Бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэхийн тулд суралцагчдаас нээлттэй асуулт асуух, өөрийн байр сууринаас асуудалд хандаж, чөлөөтэй бодож сэтгэхүйц даалгаврын олон хэлбэр сонголт бүхий тестээр суралцагчийн мэдлэг чадварыг үнэлэх нь чухал байгааг судалгааны үр дүн харуулж байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Жадамбаа, Б., Чимэдлхам, Ц. (2011). *Судалгааны аргазүй*. Улаанбаатар: Гэрэлт Судар
- Пагмасүрэн, Ц. (2015). “Үйлийн судалгааны аргазүй”. *МБУС. Дидактикийн их семинар*. Улаанбаатар
- Пүрэвдорж, Ч. (2009). *Багшлахуйн менежмент*. Улаанбаатар